



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/103/СТА-ТШЗ

Баянхонгор хот 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584, 99007576 Цахим хаяг: munkhbat.B@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Цэцэгмаа
Утас: 70442424,88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn
Ахлах аудитор: А.Цээням
Утас: 99442140, 88011833 Цахим хаяг:tseenyam.A@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийсэн үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	9
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.8.1	Санхүүгийн тайланд залруулсан алдаа, зөрчилтэй асуудал	9
2.8.2	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	10
2.8.2.1	Төлбөрийн акт тогтоосон зөрчилтэй асуудал.....	10
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
	байхгүй	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	15
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	17
3.4	АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	19
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2019.02.25 № 2/67

танай _____ -ны № _____ -т

Г _____ Г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа

2019 on gerchilgee_Bayankhongor aimgiin ITH.docx

2515115

нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитыг хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem.

Б.МӨНХБАТ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Баянхонгор аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Т.Эрдэнэбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийсэн үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.22-ноос 2019.02.25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор А.Цээням хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.25-ны өдөр 2019.01.03-ны өдрийн 16/09 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор аймгийн ИТХ нь “Нутгийн өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлж, төлөвшүүлэн аймаг, орон нутгийнхаа нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх ард иргэдийнхээ төлөөлөх эрхийг хангахад оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Тайлант Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг жигд тасралтгүй явуулж аймаг орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого, чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэхэд гадаад, дотоодын байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй нягт уялдаа холбоотой хамтран ажиллах зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Засаг захиргааны нэгж түүний удирдлагын тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг БНА-2019/103/СТА-ТШЗ

алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн Acolous санхүүгийн тооцоолох программ”, “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн Acolous санхүүгийн тооцоолох программ, “Payroll 2018” цалингийн программ” хангамж ашиглаж гүйцэтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар сонгов.

Материаллаг байдлын суурийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэв.

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 681880,7 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 13637,6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 10 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн талаарх мэдээллийг В30102 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Санхүүгийн тайланд залруулсан алдаа, зөрчилтэй асуудал

- 2018 онд санхүүгийн тайланд авлагыг 120776 төгрөгөөр, өглөгийг 987566 төгрөгөөр илүү тусгасан байна..

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2 "НББ-д бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага".14.4.3 " бүх өр төлбөрийн заавал тусгана" гэсэн заалтуудыг зөрчсөн, мөн Үнэн зөв байх батламж мэдэгдэл хангаагүй байна.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	44630,9	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	991,6	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
	Дүн	4	45622,5	

2.8.2. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.2.1 Төлбөрийн акт тогтоосон зөрчилтэй асуудал

Зардлын данстай холбоотой асуудал

Тус байгууллага 12 дугаар сард ажилтануудад илүү цагийн хөлсөнд 347.0 мянга төгрөгийг олгосон мөн нягтлан бодогч хурлын тэргүүлэгч нарын урамшуулалт цалингаас ХХОАТ-ыг 520.4 мянга, цалингаас 124.2 мянган төгрөгийг тус тус дутуу тооцож авсан байна.

Энэ нь Үнэ зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн, 6.4.1-т “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхдээ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах зарчмыг хэрэгжүүлэх”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т “Энэ хуулийн 17 дугаар зүйл, 22.1.4-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ БАЙХГҮЙ

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5

дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан Орон нутгийн төсвөөс 585192,6 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төсөв батлагдаж бүрэн авч зарцуулж батлагдсан төсвийг хэтрүүлээгүй ба зарцуулаагүй үлдэгдэл 62,8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ

Нэмэлт санхүүжилтийн дансанд НҮБ-ийн "Нутгийн өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэх нь" төслөөс 44008,5 мянган төгрөгийн санхүүжилт ирснийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Тус байгууллага нь Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд хийсэн "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит", санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 24 мэдээллээс 5 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Мөн хуулийн 6.4-д заасан мэдээллээс өөрт хамаарах 5,0 сая төгрөгөөс үнийн дүн бүхий 12 гүйлгээ мэдээлэхээс 12-р сард 1 гүйлгээний 11,8 сая төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг хоцроож мэдээлсэн байна. Цаашид мэдээллийг хугацаанд нь үнэн зөв мэдээлж байхыг нягтлан бодогчид, хяналт тавьж ажиллахыг захиралд зөвлөв.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

2017 оны санхүүгийн тайлангийн зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянхонгор аймгийн ИТХурал нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Мөнгөн хөрөнгийн данс

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант онд хийгдсэн НББ-ийн дансны бичилтүүдийг хянаж үзэхэд 32595.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг тооцоо үүсгэлгүй зардалд бүртгэсэн, мөнгөн

гүйлгээний тайланд залруулсан гүйлгээний 5375.9 мянган төгрөгийг орлогоор бүртгэсэн байна.

Энэ нь Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйл 26.1 “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Тайлант хугацаанд бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламжийг нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэлд бүрэн тусгаагүй нуун дарагдуулсан байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Мөнгөн хөрөнгийн данснаас гарсан бүх гүйлгээг тооцооны дансаар дамжуулан тооцоо үүсгэн зарцуулалтыг зарлага, нэхэмжлэхийн дагуу гарган бүртгэж Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1-р хавсралтын 4.5б дэхь заалт, Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйл 26.1 “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвшөөрч байна

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас худалдан авсан 6660.0 мянган төгрөгийн үнэ бүхий аймгийн ИТХ-ын хүндэтгэл, одон тэмдэгийг нярав хөрөнгийг бараа материалын дансанд орлого авч зарцуулалтыг гаргаагүй, нягтлан бодогч шилжүүлсэн дүнгээр тайланд шууд зардлаар бүртгэсэн байна

Энэ нь Үнэн зөв, оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж үнэн зөв толилуулах үүрэгтэй гэсэнтэй заалттай нийцээгүй байна.

3.2.2 Эрсдэл: Хөрөнгө үрэгдэх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Худалдан авсан хөрөнгийг нярав бараа материалын тайланд тухай бүр нь тусгаж, санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлж, хөрөнгөнд бүртгэлээр тавих дотоод хяналтаа сайжруулах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвшөөрч байна

3.3 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

3.3.1 Илрүүлэлт:

Аудитаар хурлын хуралдааны хоолны зардалд 32358,0 мянган төгрөгийг зарцуулахдаа тушаал гаргаагүй төлөөлөгчдөөр бус оролцсон нийт хүмүүсийг хавтгайруулан хооллож гүйцэтгэлд хяналт тавиагүй нь ажиглагдсан, мөн үйлчилгээг худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийг хэрэгжүүлээгүй.

Баянхонгор аймгийн ГХУС ажлыг зохицуулах зөвлөлийн зардлад 81.2 сая төгрөгийг зарцуулахдаа Зөвлөлийн баталсан зардлын төсвийн хуваариар олгоогүй 18.3 сая төгрөгийг хэтрүүлэн 14 суманд 38.3 сая төгрөгийг олгосон.

ИТХ-ын төлөөлөгч нарын тойрогт ажиллах зардлыг олгохдоо анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй, зөвхөн хэрэгжилтийн тайлангуудыг авсан байна.

Энэ нь Үнэн зөв байх, тодруулга толилуулга батламж мэдэгдэлтэй нийцээгүй, НББ-ийн тухай хуулийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл: Батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулаагүй байх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Хурлын хуралдааны хоолны зардлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулан, төлөөлөгчдийн тоогоор зардлыг гарган Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1., 13.7 дахь заалтуудын дагуу анхан шатны баримтыг бүрдүүлж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах. Мөн ГХУСАХ-ний зардлыг зөвлөлийн баталсан шийдвэрийн дагуу зарцуулж Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхдээ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах зарчмыг хэрэгжүүлэх” гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 5 дугаар сарын 01-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

төгрөг

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>14,762,352.00</u>	<u>11,636,031.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	34,200.00	00.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	34,200.00	00.00
31110	Төгрөг	34,200.00	00.00
33	АВЛАГА	00.00	2,689.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	2,689.00
34	УРЬДЧИЛГАА	251,142.00	251,142.00
3471	Урьдчилгаа тооцоо	251,142.00	251,142.00
34713	Цалингийн урьдчилгаа	251,142.00	251,142.00
35	БАРАА МАТЕРИАЛ	14,477,010.00	11,382,200.00
354	Хангамжийн материал	14,477,010.00	11,382,200.00
35410	Бичиг хэргийн материал	833,110.00	833,110.00
35420	Аж ахуйн материал	13,643,900.00	10,549,090.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>71,136,036.99</u>	<u>21,354,420.26</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	71,136,036.99	21,354,420.26
392	Биет хөрөнгө	71,136,036.99	21,354,420.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	31,453,000.00	2,268,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-8,458,843.60	-1,362,531.99
39203	Авто-тээврийн хэрэгсэл	147,827,000.00	147,827,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-127,250,763.42	-146,378,221.92
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	54,944,333.00	54,944,333.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-39,067,386.24	-44,914,018.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,676,166.00	28,676,166.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,555,768.75	-20,274,606.79
39217	Ном	568,300.00	568,300.00
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>85,898,388.99</u>	<u>32,990,451.26</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,307,396.00</u>	<u>1,046,944.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,307,396.00	1,046,944.00
413	Өглөг	1,307,396.00	1,046,944.00
4136	Бусад өглөг	65,089.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	65,089.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>84,590,992.99</u>	<u>31,943,507.26</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	84,590,992.99	31,943,507.26
511	Засгийн газрын оруулсан капитал	206,028,121.00	206,028,121.00
51101	Өмч: - төрийн	206,028,121.00	206,028,121.00
512	Хуримтлагдсан үр дүн	-123,840,794.01	-176,488,279.74
51210	Өмнөх үеийн үр дүн	-123,840,794.01	-123,840,794.01
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-52,647,485.73
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,403,666.00	2,403,666.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>85,898,388.99</u>	<u>32,990,451.26</u>

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

төгрөг

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	409,574,925.00	629,233,238.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	200,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	200,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	200,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	409,374,925.00	629,233,238.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,782,115.00	44,008,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,782,115.00	44,008,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	378,592,810.00	585,192,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	378,592,810.00	585,192,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	32,138.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	32,138.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	430,958,712.47	660,073,043.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	430,958,712.47	660,073,043.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	403,250,035.47	602,853,103.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	140,549,463.00	146,146,635.00
210101	Үндсэн цалин	132,989,463.00	102,142,164.00
210102	Нэмэгдэл	7,560,000.00	5,400,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	7,986,000.00
210104	Урамшуулал	00.00	30,618,471.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,594,841.00	17,489,914.00
210201	Тэтгэврийн даатгал	10,534,248.00	15,837,744.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,160,738.00	443,909.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,116,530.00	355,127.00
210204	Ажилгүйдлийн даатгал	253,029.00	88,781.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,530,296.00	764,353.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,698,045.00	37,822,397.00
210401	Бичиг хэрэг	1,517,120.00	2,710,380.00
210402	Тээвэр, шатахуун	27,009,640.00	32,300,330.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,171,285.00	2,811,687.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,572,300.00	14,955,410.00
210604	Урсгал засвар	5,572,300.00	14,955,410.00
2107	Томилолт, зочны зардал	9,000,000.00	67,200,000.00
210701	Гадаад албан томилолт	00.00	58,426,000.00
210702	Дотоод албан томилолт	9,000,000.00	8,774,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,949,947.00	27,210,411.00

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,156,100.00	24,973,411.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	100,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,406,900.00	2,060,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	130,800.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	256,147.00	77,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	166,885,439.47	292,028,336.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	116,930,283.00	209,983,850.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,036,450.00	54,070,550.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,918,706.47	27,973,936.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,708,677.00	57,219,940.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,693,796.00	57,157,109.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	32,138.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,426,896.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,856,400.00	2,970,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн	00.00	30,154,971.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,410,500.00	24,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,881.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,881.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	62,831.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	62,831.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-21,383,787.47</u>	<u>-30,839,805.66</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	21,807,680.07
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	21,807,680.07
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-21,807,680.07
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-21,383,787.47</u>	<u>-52,647,485.73</u>

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-3А

төгрөг

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>409,574,925.00</u>	<u>629,233,238.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	200,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	200,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	200,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	409,374,925.00	629,233,238.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,782,115.00	44,008,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,782,115.00	44,008,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	378,592,810.00	585,192,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	378,592,810.00	585,192,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	32,138.00

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	32,138.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	409,574,925.00	629,267,438.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	409,574,925.00	629,267,438.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	381,782,748.00	572,047,498.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	138,903,823.00	146,280,901.00
210101	Үндсэн цалин	88,057,823.00	85,963,200.00
210102	Нэмэгдэл	43,646,000.00	2,403,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,200,000.00	7,986,000.00
210104	Урамшуулал	00.00	49,928,701.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,066,200.00	17,553,700.00
210201	Тэтгэврийн даатгал	15,066,200.00	15,060,297.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	623,351.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	498,680.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	124,669.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	1,246,703.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,287,545.00	29,667,397.00
210401	Бичиг хэрэг	1,716,260.00	2,708,260.00
210402	Тээвэр, шатахуун	20,400,000.00	24,147,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,171,285.00	2,811,687.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,472,300.00	11,600,000.00
210602	Тавилга	9,900,000.00	00.00
210604	Урсгал засвар	5,572,300.00	11,600,000.00
2107	Томилолт, зочны зардал	9,000,000.00	67,200,000.00
210701	Гадаад албан томилолт	00.00	58,426,000.00
210702	Дотоод албан томилолт	9,000,000.00	8,774,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,949,947.00	27,275,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,156,100.00	25,038,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	100,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,406,900.00	2,060,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	130,800.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	256,147.00	77,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	144,102,933.00	272,470,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	127,066,483.00	218,399,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,036,450.00	54,070,550.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,792,177.00	57,219,940.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,777,296.00	57,157,109.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	32,138.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,426,896.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,050,400.00	2,970,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	30,154,971.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,300,000.00	24,000,000.00

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,881.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,881.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	62,831.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	62,831.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	-34,200.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	-34,200.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	34,200.00	34,200.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	34,200.00	00.00

3.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

СТ-4А

төгрөг

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	206,028,121.00	2,403,666.00	-123,840,794.01	84,590,992.99
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	206,028,121.00	2,403,666.00	-123,840,794.01	84,590,992.99
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-52,647,485.73	-52,647,485.73
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	206,028,121.00	2,403,666.00	-176,488,279.74	31,943,507.26

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

төгрөг

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		34200.0		34200.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	378,592,800.00	378,577,929.00	585,192,600.00	585,163,969.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	378,592,800.00	378,577,929.00	585,192,600.00	585,163,969.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	378,592,800.00	378,577,929.00	528,067,600.00	528,038,998.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	139,666,000.00	138,703,823.00	146,281,100.00	146,280,901.00
210101	Үндсэн цалин	88,820,000.00	87,857,823.00	85,963,200.00	85,963,200.00
210102	Нэмэгдэл	43,646,000.00	43,646,000.00	00.00	2,403,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,200,000.00	7,200,000.00	7,986,000.00	7,986,000.00

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210104	Урамшуулал	00.00	00.00	52,332,000.00	49,928,701.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,066,200.00	15,066,200.00	17,199,100.00	17,553,700.00
210201	Тэтгэврийн даатгал	00.00	00.00	11,820,300.00	15,060,297.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	1,433,300.00	623,351.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	1,146,700.00	498,680.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	286,700.00	124,669.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	2,866,700.00	1,246,703.00
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00	00.00	29,695,800.00	29,667,397.00
210401	Бичиг хэрэг	1,678,000.00	1,716,260.00	2,678,000.00	2,708,260.00
210402	Тээвэр, шатахуун	20,917,200.00	20,400,000.00	23,517,800.00	24,147,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,199,000.00	4,171,285.00	3,000,000.00	2,811,687.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	00.00	500,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	00.00	11,600,000.00	11,600,000.00
210602	Тавилга	9,900,000.00	9,900,000.00	00.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	238,000.00	00.00	00.00	00.00
210604	Урсгал засвар	4,473,000.00	5,572,300.00	11,600,000.00	11,600,000.00
2107	Томилолт, зочны зардал	9,000,000.00	9,000,000.00	67,200,000.00	67,200,000.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00	60,000,000.00	58,426,000.00
210702	Дотоод албан томилолт	9,000,000.00	9,000,000.00	7,200,000.00	8,774,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	00.00	7,537,000.00	7,537,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,791,300.00	7,169,500.00	5,300,000.00	5,300,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	99,000.00	00.00	100,000.00	100,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,406,900.00	1,406,900.00	2,060,000.00	2,060,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	130,800.00	130,800.00	77,000.00	77,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	314,000.00	256,147.00	00.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	140434900.00	137307418.00	248200000.00	248200000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	124,398,450.00	121,270,968.00	215,800,000.00	217,757,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,036,450.00	16,036,450.00	32,400,000.00	30,442,550.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00		57125000.00

Баянхонгор аймгийн ИТХ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	00.00	57,125,000.00	57,125,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,427,800.00	5,426,896.00		00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,050,400.00	9,050,400.00	2,970,000.00	2,970,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,300,000.00	13,300,000.00	30,155,000.00	30,154,971.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00	24,000,000.00	24,000,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	378,577,929.00	585,192,600.00	585,129,769.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	34,200.00	00.00	34,200.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	34,200.00	00.00	00.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	11	11	11	11
620001	Удирдах ажилтан	4	4	4	4
620002	Гүйцэтгэх ажилтан	2	2	2	2
620003	Үйлчлэх ажилтан	5	5	5	5
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	5	5	5	5
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4	4	4	4
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	2	2	2	2